

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН ЗҮҮН БҮС ДЭХ ГАЗРЫН
2018 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2018 оны 11 дугаар сарын 25

Чойбалсан хот

Арга хэмжээ /гарц/-ийн шалгуур үзүүлэлт /тоо, чанар, хугацаа/-ийн хүрэх түвшинь	Жинхэнэ гүйцэтгэл /тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин/	Үнэлгээ /нийт арга хэмжээ бүрийн биелэлтэд 0-30 оноо/
1	2	3
<p>1.1.1. Орон нутгийн төрийн захиргааны болон хяналтын байгууллагуудаас зохион байгуулсан уулзалт, зөвлөгөөн, сургалтанд оролцох Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Байгууллагын үндсэн чиг үүргийг талаар үнэн зөв ойлголттой болсон байна Хугацаа: Сардаа</p>	<p>Бүсийн газрын дарга Дорнод аймгийн “Удирдах ажилтны шуурхай хуралдаан”-д 3 удаа биечлэн сууж орон нутгийн удирдлагаас өгсөн үүрэг, чиглэл мэдээллийг тухай бүр шуурхай хуралдаанаар хүргэн ажилласан. Мөн Сүхбаатар аймаг дахь хэлтсийн дарга харьяа аймгийн удирдах ажилтны шуурхай хуралдаанд байгууллага төлөөлөн сууж орон нутгийн талаарх мэдээ, мэдээллийг авч ажилласан. Бүсийн газар Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Төрийн албаны зөвлөлөөс хамтран зохион байгуулж байгаа Төрийн жинхэнэ албан хаагчдын ажил, мэргэшлийн төвшинг үнэлэх арга хэмжээний хүрээнд тус ажлын хэсгээс тавьсан шаардлагын дагуу материалуудыг бэлдэн 11 дүгээр сарын 16-ний өдөр шалгуул дүгнүүлсэн. Шалгалтаар Бүсийн газрын ажил байдлыг 100 хувь гэж үнэлсэн. Тестийн онлайн шалгалтад Бүсийн төвд 7, хилийн боомтуудад 6, Сүхбаатар аймагт 2 нийт 15-н захиргааны албан хаагч хамрагдаж амжилттай өгцгөөсөн.</p>	
<p>1.1.2. Нутгийн захиргааны болон хяналтын бусад байгууллагатай хамтран ажиллах Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль тогтоомжийн талаар нэг мөр ойлголт өгөх Хугацаа: Сардаа</p>	<p>Дорнод аймаг дахь Прокурорын газраас зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн материалыг хянаж хуулийг нэг мөр хэрэгжүүлж, ажил сайжруулах тухай 13/679 тоот албан бичгийг ирүүлсэн. Албан бичгийн хариуг 17/380 тоот албан бичгээр хүргүүлж, хяналтын улсын байцаагч нарт прокурорын газраас ирүүлсэн албан тоотыг танилцуулж дахин энэ төрлийн алдааг гаргахгүй ажиллах, Улсын Ерөнхий Прокурорын 2018 оны А/01 дүгээр тушаалаар баталсан “ЗАГВАР”-ыг мөрдөн ажиллахыг үүрэг болгохын зэрэгцээ, өөрийн байгууллагын зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны нөхцөл байдлын онцлогтой уялдуулж хяналтын улсын байцаагчдын ажлын</p>	

	хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор “Зөвлөмж”, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тэмдэглэлийн “Загвар”-ыг файлаар хяналтын улсын байцаагч нэг бүрд хүргүүлж ажилласан.	
1.2.1. Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”, “Гадаадын иргэн, харьяатын газрын орон нутаг дахь газрын ажиллах журам”-ын хэрэгжилтийг ханган, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хэрэгжүүлэн ажиллах, үр дүнг тайлагнах Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Үйл ажиллагааны үр дүн гарсан байна Хугацаа: Сардаа	Бүсийн газар нь шинэ байранд орсонтой холбоотой байрны харуул хамгаалалт зохион байгуулах ажлын зайлшгүй шаардлагаар Ц.Хүрэлдорж, Т.Ганхүү, Ш.Болд гэх 3 хүний материалыг Тамгын газрын хүний нөөцөөр уламжлуулан байгууллагын даргад танилцуулж тус сараас хөлсний гэрээгээр ажиллуулж байна. Тамгын газрын даргаар 11 дүгээр сард албан хаагчдын хилийн боомтод ажиллах хуваарийг батлуулан хуваарийн дагуу албан хаагчид ажиллаж байна. Мөн энэ сарын 7-с 11-ний өдрүүд, 24-с 26-ний өдрүүдэд амралтын олон хоногууд тохиож байсан тул тус өдрүүдэд Бүсийн газартаа аюулгүй байдлыг хангах үүднээс хариуцлагатай жижүүрийн хуваарь баталж ажилласан.	
2.1.1. Монгол Улсад цагаачлан оршин сууж байгаа гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлт болон иргэний харьяаллын асуудлаар гаргасан бусад хүсэлтийг хүлээн авч зөвлөгөө өгөх, хүлээн авсан баримт бичгийн бүрдлийг Харьяатын газарт хүргүүлэх Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Төрийн үйлчилгээг, түргэн шуурхай хүргэсэн байна Хугацаа: Сардаа	Иргэний харьяат, цагаачлалын талаар гаргасан хүсэлт ирээгүй.	
3.1.1. Гадаадын иргэнд Монгол Улсын энгийн зэргийн виз олгох, хугацаа сунгах, визийн зөвшөөрөл хүссэн тухай Виз, зөвшөөрлийн газарт уламжлан шийдвэрлүүлэх Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Төрийн үйлчилгээг, түргэн шуурхай хүргэсэн байна Хугацаа: Сардаа	Бүсийн газар түүний харьяа хилийн боомтуудад БНХАУ-ын 49 иргэнд зохих ангилал, зориулалтын дагуух визийг олгосон. Үүнд: “ НГ ” ангиллын визийг 32 иргэнд олгосон. Үүнээс: --Нэг удаагийн “гарах-орох” зориулалттай виз -10 --Визийн шилжүүлэг- 22 иргэнд; “ В ” ангиллын визийг 3 иргэнд олгосон. Үүнээс: --Нэг удаагийн “орох” зориулалттай виз -1 /02/18-8023 тоот визийн зөвшөөрлийн дагуу, Хавирга боомтод/ --Олон удаагийн “орох” зориулалттай виз -2 /02/18-7499, 02/18-7777 тоот зөвшөөрлийн дагуу Бүсийн төв болон Хавирга боомтод олгосон./	

	<p>“S” ангиллын визийнг 10 иргэнд олгосон. Үүнээс: --Нэг удаагийн “гарах-орох” зориулалттай виз -10; “Н” ангиллын визийг 4 иргэнд олгосон. Үүнээс: --Нэг удаагийн “гарах-орох” зориулалттай виз -2; --Хоёр удаагийн “гарах-орох” зориулалттай виз -1; --Олон удаагийн “гарах-орох” зориулалттай виз -1 тус тус олгож ажиллалаа. Ольхон” ХХК -аас БНХАУ-ын 1 иргэнд “В” ангилалын олон удаагийн визийн зөвшөөрөл хүссэн хүсэлт, “Хаан хүнс” ХХК -аас БНХАУ-ын 1 иргэнд “В” ангилалын олон удаагийн визийн зөвшөөрөл хүссэн хүсэлт, “Сан Хэрлэн” ХХК -аас БНХАУ-ын 1 иргэнд “В” ангилалын олон удаагийн визийн зөвшөөрөл хүссэн хүсэлтийг тус тус хүлээн авч холбогдох бичиг баримт, материалын бүрдлийг хангуулан Виз, зөвшөөрлийн газарт илтгэх хуудсаар танилцуулан 02/18-7905, 02/18-8023 тоот зөвшөөрлийн дагуу виз олгосон.</p>	
<p>3.1.2. Монгол Улсад зорчих хувийн урилга олгох Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Төрийн үйлчилгээг, түргэн шуурхай хүргэсэн байна Хугацаа: Сардаа</p>	<p>Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилга хүсээгүй.</p>	
<p>3.1.3. Оршин суух зөвшөөрөл, хугацаа сунгах, хасах, оршин суух үнэмлэх авах, өөрчлөлт бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авах, хянах хүсэлтийг хүлээн авч Виз, зөвшөөрлийн газарт уламжлан шийдвэрлүүлэх Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Төрийн үйлчилгээг, түргэн шуурхай хүргэсэн байна Хугацаа: Сардаа</p>	<p>Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй 1 аж ахуйн нэгжийн хүсэлтийн дагуу НГ ангиллын орох визээр орж ирсэн БНХАУ-ын 1 иргэнийг түр ирэгчээр бүртгэсэн. Мөн зөрчил гаргасан 9 иргэнийг түр ирэгчээр, Монгол Улсад байх визийн хугацааг сунгалт хийлгэсэн БНХАУ-ын 6 иргэнийг түр ирэгчээр нийт 14 иргэнийг бүртгэж, 11 иргэнд хасалт хийсэн байна. /Түр ирэгч бүртгэл-14, хасалт-11/ Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй 1 аж ахуйн нэгжийн хүсэлтийн дагуу оршин суух зөвшөөрлийн хасалт 1 иргэнд хийсэн байна. Дорнод аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн ирүүлсэн хүсэлтийн дагуу сургуулийн сайн дурын ажилтан болох Япон улсын 2 иргэний Монгол улсад оршин суух хаягын өөрчлөлт хийлгэх материалыг хүлээн авч, албан бичиг боловсруулан Виз, зөвшөөрлийн газарт шуудангаар хүргүүлсэн.</p>	
<p>3.1.4. Монгол Улсад түр ирэгч гадаадын иргэнийг бүртгэх, хасах, түүнчлэн хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэхтэй гадаадын иргэнийг бүртгэх, хасах Тоо хэмжээ: Тухай бүр</p>	<p>ХОНДЗҮ-ээр нэвтэрсэн нийт БНХАУ-н 160 иргэнийг бүртгэж, 151 иргэнийг хассан байна. Үүнээс Бичигт боомтод бүртгэсэн 75, хассан 74, Сүмбэр боомтод бүртгэсэн 17, хассан 17, Баянхошуу бүртгэсэн 10, хассан 6, Хавирга боомтод бүртгэсэн 58, хассан 54 иргэнийг тус бүр бүртгэж хассан байгна.</p>	

<p>Чанар: Төрийн үйлчилгээг, түргэн шуурхай хүргэсэн байна Хугацаа: Сардаа</p>		
<p>3.1.5. Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суухаар анх удаа ирсэн гадаадын иргэний хурууны хээ бусад мэдээллийг журмын дагуу авч нэгдсэн санд оруулах Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Төрийн үйлчилгээг, түргэн шуурхай хүргэсэн байна Хугацаа: Сардаа</p>	<p>Монгол Улсад анх удаа хөдөлмөр эрхлэхээр ирсэн нийт 4 гадаадын иргэний хурууны хээг “Transient card system” програмаар бүртгэн авч, мэдээллийн баазад оруулсан.</p>	
<p>3.2.1. Монгол Улсад түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суугаа гадаадын иргэн, аж ахуй нэгж, байгууллагад удирдамжийн дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг дангаар буюу хяналтын бусад байгууллагатай хамтран зохион байгуулна Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>ГИХГ-ын Зүүн бүс дэх газар нь тайлангийн хугацаанд бүсийн газрын даргын баталсан №17/02-201842 тоот удирдамжийн дагуу төлөвлөгөөт 1, 17/02-201843 удирдамжийн дагуу төлөвлөгөөт бус 1, Сүхбаатар аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбаатарын баталсан удирдамжийн дагуу төлөвлөгөөт бус 1, нийт 3 удаагийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Шалгалтанд 3 аж ахуй нэгжийн, гадаадын 21 иргэн хамрагдсан, илэрсэн зөрчил байхгүй.</p>	
<p>3.2.2. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд заасан зөрчил гаргасан гадаадын иргэдийн зөрчлийг арилгаж, зөвлөгөө өгч ажиллана Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>Тайлангийн хугацаанд бүсийн хэмжээнд нийт 4 зөрчлийг илрүүлж, “Ган-Ширээс” ХХК-д 60000 /жаран мянга/-н төгрөг, зөрчил гаргасан БНХАУ-ын 3 иргэнд нийт 1,600.000.0 /нэг сая зургаан зуун мянга/-н төгрөг нийт 1,660.000.0 /нэг сая зургаан жаран мянга/-н төгрөгийн торгуулийн арга хэмжээг авч зөрчлийг шийдвэрлэсэн байна.</p>	

<p>3.2.3. Хууль, тогтоомж зөрчсөн гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргана Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>Тайлангийн хугацаанд визийн байх хугацааг 2 сараас дээш хугацаагаар хэтрүүлсэн БНХАУ-ын 1 иргэнийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37.1.12 дахь заалт Засгийн газрын 2010 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”-ын 3.12.1 дэх хэсэгт тус тус зааснаар 1 жилийн хугацаанд Монгол Улсад дахин орох эрхгүйгээр Монгол Улсаас албадан гаргасан.</p>	
<p>3.2.4. “Монгол Улсын виз олгох журам”-ын 5.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр визийг хүчингүй болгоно Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>Мөн Зүүн бүс дэх газраас алдаатай олгосон 1 визийг хүчингүй болгож, / void тэмдэг дарсан / нийт 1 виз шинээр олгосон. /</p>	
<p>3.2.5. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, тогтоомжид заагдсан үндэслэлээр гадаадын иргэнийг Хил дээрээс буцаах арга хэмжээг журмын дагуу хэрэгжүүлж ажиллана Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>Бичигт боомтод хяналтын улсын байцаагч Ц.Өлзиймөнх орох чиглэлд БНХАУ-ын 9 иргэнийг /ГИЭЗБТХ-ийн 22.1.6 дахь заалтыг Монгол Улсад байх буцаж явах хөрөнгийн эх үүсвэрийн баталгаагүй/ улсын хилээр нэвтрүүлэлгүй буцаасан.</p>	
<p>4.1.1 2018 оны Бүсийн үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөний биелэлт болон хүний нөөц, бусад шаардлагатай судалгаа мэдээллийг гарган Тамгын газар, БОНХ-т хүргүүлэх, Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Дээд шатны байгууллага, албан тушаалтан хүссэн мэдээллээ авсан байна. Хугацаа: Сардаа</p>	<p>Төвөөс ирүүлсэн үүрэг, чиглэлийн дагуу Тамгын газарт төрийн үйлчилгээний албан хаагч нарын 11 дүгээр сарын ур чадварын нэмэгдэл олгуулах санал, өргөдөл гомдлын инфо мэдээ, албан хаагчдын удаан жил болон зэрэг дэвийн нэмэгдэл олгуулах санал, албан хаагчдын амьдрах орчин, бүтээн байгуулалтын ажилд санаачилгатай ажилласан албан хаагчдыг цалингийн хувиар урамшуулах санал, мөн байгууллагын дотоод үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн актад оруулах санал, хяналтын улсын байцаагч нарын сургалтад суулгах албан хаагчдын санал зэргийг, Боомт орон нутгийн хэлтэст Бүсийн газрын 10 дугаар сарын үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөний биелэлт, инфо мэдээ, Бүсийн газрын даргын 11 дугаар сарын төлөвлөгөө, 2019 онд Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудын засаг дарга нарын ХЗДХ-н сайдтай байгуулах гэрээнд тусгуулах саналыг тус</p>	

	тус гаргаж “и оффис” хаягаар хүргүүлсэн.	
<p>5.1. Байгууллагын баримт бичгийн эргэлтийг зохион байгуулах, бүртгэлжүүлэх, сан үүсгэх Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>Ирсэн бичиг: Гадаадын иргэн харьяатын газраас 6, бусад байгууллагаас 9 нийт 15 албан бичиг ирж, үүнээс хариутай 8 албан бичгийн хариуг хуулийн хугацаанд өгч шийдвэрлэсэн. Явсан бичиг: Гадаадын иргэн, харьяатын газарт 6, албан хаагчдад 2, бусад байгууллагад 25 нийт 33 албан бичиг явуулж үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, албан бичгийн хариуг хүргэж ажилласан. Өргөдөл: Тус сард албан хаагчдаас хувийн чөлөө хүссэн 4, ХДЖ-н дагуу чөлөө хүссэн 1, ээлжийн амралтаа түрүүлж эдлэхийг хүссэн 1 нийт 6-н өргөдлийг хүлээн авч тухай бүр нь шийдвэрлэж ажилласан. Тайлангийн сард иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хандаж гаргасан өргөдөл, мэдээлэл, гомдол, хүсэлт ирээгүй байна.</p>	
<p>6.1.1. Төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж ажиллах. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Зориулалтын дагуу зарцуулсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>2018 оны 11 дугаар сард 63,147,900.00 төгрөгийн санхүүжилтийг авсан. Үүнээс 47,152,207.37 төгрөгийн зарлагын гүйлгээг батлагдсан төсвийн хүрээнд зориулалтын дагуу хийж гүйцэтгэсэн. 2018 оны 10 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 410,152,600.00 төгрөгийн санхүүжилт, 367,661,702.94 төгрөгийн гүйцэтгэлтэй, 42,490,897.06 төгрөгийн үлдэгдэлтэй гарсныг газрын даргаар баталгаажуулан аймгийн төрийн сан болон ГИХГ-ын санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан.</p>	
<p>6.1.2. Тэмдэгтийн хураамжийн болон хүү, торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>Хяналтын улсын байцаагч болон боомтын визийн хуудасны 10 дугаар сарын тайлангаар улсын тэмдэгтийн хураамж орлогод 5,738,000.00 төгрөг, хүү, торгуулийн орлогод 3,650,000.00 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.</p>	

<p>6.2.1. Бүсийн төв болон бусад нэгж, техник хэрэгсэлд шаардлагатай бараа материал, эд зүйлээр нь хангаж ажиллах Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Тооцоо судалгаа хийгдсэн байна Хугацаа: Сардаа. /тусгай арга хэмжээ/</p>	<p>Мөн тус ард доорх худалдан авалтуудыг хийсэн байна. Үүнээс бичиг хэргийн хэрэгцээнд: принтерийн шинэ хор 24 ширхэг, бичгийн цаас 50 боодол, цаас зүсэгч 1 ширхэг, өнгөт хор 1 ком, сүлжээний толгой 50 ширхэг, принтерийн плат 1 ш, эх хавтан 1 ш, адаптар 1 ширхгийг авсан. Байгууллагын шинэ байрны тохижилттой холбогдуулан хүрз, түлхүүр багаж, амралтын өрөөнд гал тогооны хэрэгсэл, гадна хаалганы хийн татуурга, граж коридорын хэсэгт гэрлийн ламп, цахилгааны төв самбарын хайрцаг, реле, түлхүүрийн хайрцаг, гадна, дотно орчны цэвэрлэгээний багаж хэрэгсэл, ариутгалын бодис зэргийг тус тус худалдан авсан байна.</p>	
<p>6.2.2. Тээврийн хэрэгсэл, автомашинуудын өвлийн бэлтгэлийг хангуулж ажиллах. Тоо хэмжээ: 3 машин Чанар: Стандарт, нормыг баримталсан байна. Хугацаа: Сардаа. /Тусгай арга хэмжээ/</p>	<p>Бүсийн Техникийн комиссын 05 дугаар хурлыг хуралдуулж бүсийн газрын төвд ашиглагдаж байгаа 75-55 ДОА улсын дугаартай “НИССАН ПАТРОЛ” автомашины хойд амортизатор хугарсан, наклад элэгдэж дууссан, дугуй муудсан тул эвдрэл гэмтлийн талаар хэлэлцэж сэлбэг шинээр худалдан авч тавихаар шийдвэрлэсэн.</p>	
<p>6.2.3. Бүсийн газрын шинэ байрны тохижилтын ажлыг үргэлжлүүлэх Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Стандарт, нормыг баримталсан байна. Хугацаа: Сардаа. /Тусгай арга хэмжээ/</p>	<p>Албаны шинэ байрны тохижилтоор гадна талбайн хойд хэсэгт тоосгоор талбай засаж 2 ширхэг сандал, үнсний сав суулгаж шинээр тамхины цэг байгуулсан. Мөн босоо цэвэрхэн хогний сав авч явган хүний зам дагуу газарт суулгаж байрлуулсан.</p>	
<p>7.1.1. “ISM” системийн сайжруулалт, хөгжүүлэлтийг тухай бүр гүйцэтгэж, албанд ашиглана Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Найдвартай системтэй байна Хугацаа: Жилдээ /тусгай арга хэмжээ/</p>	<p>10 дугаар сарын 25-ний өдрөөс 11 дүгээр сарын 25-ний өдрийг дуустал Бүсийн газар болон харьяа хилийн боомтуудын сүлжээнд хяналт тавьж, ISM систем гарсан зөрчилгүй хэвийн ажилласан. Ахлах мэргэжилтэн Д.Дэлэг, хяналтын улсын байцаагч Г.Хосбаатар, мэргэжилтэн Б.Одмаа нарын “ISM” програмын шилжүүлэх эрхийг бүртгэн авч, Мэдээлэл технологийн хэлтэст танилцуулан тус програмын эрхийг шилжүүлсэн. Eset endpoint security антивирусны програмыг хилийн боомтуудын нийт 10 компьютеруудад 11 дугаар сарын шинэчлэлтийг хийж хортой кодоос урьдчилан сэргийлж ажилласан байна. Хяналтын улсын ахлах байцаагч нарын иргэдтэй хийх ярилцлагын өрөөнд дотоод сүлжээний монтаж татан сүлжээнд холбосон. Хилийн боомтод үүрэг</p>	

	гүйцэтгэж байгаа албан хаагчдад ISM програм болон компьютер техникийн 3-н удаагийн зөвлөгөө өгсөн байна	
<p>7.1.2. Албан үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютер, тоног төхөөрөмжийн урсгал засвар үйлчилгээ, эвдрэл гэмтлийг тухай бүр засварлах</p> <p>Тоо хэмжээ: Тухай бүр</p> <p>Чанар: Үйл ажиллагааны тасралтгүй байдал хангагдсан байна</p> <p>Хугацаа: Сардаа</p>	<p>Dell T1700 маркийн компьютерыг форматлан хэрэглээний программуудыг суулган ахлах нягтлан Х.Хэрлэн-Урсгалд хүлээлгэн өгсөн. Ульхан боомтын HP M1132 маркийн принтерийн плат шатсан байсныг шинээр сольж засварлан ажил үйлчилгээ явуулахад бэлэн болгон өгсөн. Мөн албаны шинэ байрны гадна камерын монтажны утсыг хүйтэнд хөлдөж хугарахаас урьдчилан сэргийлж хамгаалалтын лентээр ороож бэхжүүлсэн.</p>	

ЗҮҮН БҮС ДЭХ ГАЗАР